

**ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 3 сарын 26-ны өдөр

Дугаар 6

“ГТХЗНТ” УТҮГ

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулж удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалыг баримтлав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын албан даалгавар, захирлын тушаал, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжүүдийн сарын ажлын төлөвлөгөө, нийтийн мэдээллийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт, туслах чанараар баталсан төлөвлөгөө гэсэн хяналт тавьж биелэлтийг гаргах шаардлага бүхий 8 үзүүлэлтээр 32 баримт бичигт туссан 305 арга хэмжээг хамруулж дүгнэлээ.

Гурав. Үнэлгээ

3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 33 арга хэмжээний хэрэгжилтийг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	Үүнээс							Биелэлт (хувиар)
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
Захиргаа, санхүүгийн хэлтэс	8	1	-	4	1	1	1	-	57.5
Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс	16	5	1	3	4	1	-	2	73.6
Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс	7	2	2	1	1	1	-	-	75.7
Нэгжүүд хамтран	2	-	-	-	1	-	-	1	50.0
Дүн	33	8	3	8	7	3	1	3	69.0

Төсвийн ерөнхийлөн захирагч хянаж, төсвийн шууд захирагч баталсан хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 100%-ийн биелэлттэй 8, 90%-ийн биелэлттэй 3, 70%-ийн хэрэгжилттэй 8, 50%-ийн хэрэгжилттэй 7, 30%-ийн хэрэгжилттэй 3, хэрэгжээгүй 1, хугацаа болоогүй 3 арга хэмжээтэй, хэрэгжилт дундажаар 69.0%-тай байна.

Биелэлт хангалтгүй үнэлэгдсэн 11 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

“Үр дүнгүй” буюу 0%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

28. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах
I улирал: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 арга хэмжээ зохион байгуулсан байна.
Хэрэгжилт: ЗТХЯ, Авлигатай тэмцэх газраас хамтран 2024.01.09-ний өдөр зохион байгуулсан ХАСХОМ (Хөрөнгө орлогын мэдүүлэг) гаргах цахим сургалтад “ГТХЗНТ” УТҮГ-ын 4 албан хаагч хамрагдсан.

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй 3 арга хэмжээ:

1	<p>15. Төмөр замын байгууллагууд тээвэрлэлтийн нэгдсэн програмтай болох</p> <p>I улирал: Програм хангамж, цахим системийн нарийвчилсан ажлын даалгаврыг боловсруулсан байна</p> <p>Хэрэгжилт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/284 дүгээр тушаалаар батлагдсан ...тээврийн бичиг баримт, мэдээллийг харилцан дамжуулах, төлбөр тооцооны болон ачаа тээврийн програм хангамжийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар “ГТХЗНТ” УТҮГ-ын мэргэжилтэн ажиллаж ажлын хэсгийн тайлангийн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналд тусгах нэмэлт тайлбарыг ажлын хэсгийн ахлагч, ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-ын ТЗТХ-ийн ДАУТОГ-д 2024.02.06-ны өдөр танилцуулсан. 2024.03.05-ны өдрийн байдлаар суурь бүтэц эзэмшигч тус бүр өөрийн байгууллагад ашиглагдах програм хангамжийн ажлын даалгавар боловсруулж байна. “УБТЗ” ХНН-ийн одоо ашиглаж байгаа ачаа тээврийн програм хангамжтай уялдах, “Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горим”-ын 1.4 дэх заалтыг хангаж байхаар ажлын даалгаврыг боловсруулах тухай “Чиглэл хүргүүлэх тухай” 02/794 дугаартай албан бичиг ЗТХ-ийн дэд сайдаас 2024.02.23-ны өдөр “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК-д хүргэгдсэн. Ачаа тээврийн багц програм хангамжийн ажлын даалгаврыг боловсруулж батлуулах, програм хангамжийг хөгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, багц програм хангамжийг хөгжүүлүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх хуваарь төлөвлөгөө, ажлын даалгаврын төслийг ирүүлэх үүргийг өгсөн “Мэдээлэл ирүүлэх тухай” 231, 232 дугаартай албан бичгийг “ТТЗ” ХХК, “МТЗ” ТӨХК-д 2024.02.23-ны өдөр хүргүүлсэн.</p>
2	<p>20. ТР ТС 001/2011 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартыг орчуулан боловсруулах</p> <p>I улирал: Стандартын төслийг шинээр боловсруулсан байна.</p> <p>Хэрэгжилт: “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын тухай” Гаалийн холбооны техникийн зохицуулалт” (ТР ТС 001/2011) стандартын төслийг шинээр боловсруулж холбогдох байгууллагуудаас санал авахаар бэлтгэж байна.</p>
3	<p>29. Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг зохицуулсан дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, шинэчлэх, сайжруулах, нэгтгэх, шаардлагагүй бол хүчингүйд тооцох ажлыг зохион байгуулах</p> <p>I улирал: Хүний нөөцийн чиглэлийн 2 хөтөлбөр, 1 журмыг нэгтгэж шинэчлэн баталсан байна. Шагнал олгох журам, Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг нэгтгэж шинэчлэн баталсан байна. Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн ажиллах заавар, Захирлын зөвлөлийн ажиллах журмыг хүчингүйд тооцсон байна.</p> <p>Хэрэгжилт: “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны А/29, 2022 оны А/64 дүгээр тушаалаар тус тус баталсан Шагнал олгох журам, Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг нэгтгэж, шинэчлэн боловсруулж байна. “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2024.02.16-ны өдрийн А/08</p>

дугаар тушаалаар “Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг, мөн өдрийн А/09 дүгээр тушаалаар “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах заавар”-ыг хүчингүй болсонд тооцсон.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50%-ийн үнэлгээтэй 7 арга хэмжээ:

1	<p>4. Суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангаж ажиллах</p> <p>I-IV улирал: Нэгдсэн зурмагийн дүнгийн хурлыг улирал тутам зохион байгуулна. Нэгдсэн зурмагийн тасалдлын зорилтот үзүүлэлтийг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээврийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээг тохиролцсон байна.</p> <p>I улирал: Нэгдсэн технологийн горимыг хэрэгжүүлэхэд ГТХЗНТ дээр шаардлагатай ажилагсдыг бэлтгэн ажиллуулах.</p> <p>I-IV улирал: Шинэчлэн батлагдсан хуулийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн орон тоо, бүтцийг бэлтгэх.</p> <p>I-IV улирал: Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын нэмэлт өөрчлөлтийн санал, Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөтлөх, боловсруулах заавар, Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх заавар, Өртөөний технологийн горим боловсруулах зааврын төслийг шинээр боловсруулсан байна.</p> <p>Хэрэгжилт: Нэгдсэн зурмагийн хэрэгжилтийн дүнгийн хурал зохион байгуулахаар 157, 158, 159, 160, 161 дугаартай албан бичгээр төмөр замын байгууллагад 2024.03.13-ны өдөр мэдэгдэл хүргүүлж зурмагийн дүнгийн хурлыг 2024.03.15-ны өдөр зохион байгуулсан. Дүнгийн хуралд “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК, “МТЛ” ХХК, “МТЛож” ХХК-ийн хөдөлгөөн хариуцсан нэгжийн удирдлага, зурмагийн инженерүүд оролцсон. Дүнгийн хуралд нэгдсэн зурмагийн 2023 оны жилийн эцсийн, 2024 оны эхний 2 сарын гүйцэтгэл, суурь бүтцийн тээвэрлэлтийн хэмжээ, олон улсын харилцааны ачаа тээвэрлэлт, галт тэрэг солилцоо, хилийн болон суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, зурмагийн тасалдал, үзүүлэлтийг танилцуулж хилийн болон суурь бүтэц хоорондын солилцооны хоногийн төлөвлөлтийг харилцан уялдаатай төлөвлөх, гүйцэтгэлийг тогтмол тайлагнах, мидлинг тээвэрлэлтийн хатуу хуваарийг зуны хөдөлгөөний зурмагийн төсөлд тусгах, суурь бүтэц дэх хөдөлгөөний зуны зурмагийн төслийг журамд заасан хугацаанд ирүүлэх тухай шийдвэр гарсан. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн ажлын тайлан, албан даалгавар, дүнгийн хурлын тэмдэглэлийг ЗТХЯ, суурь бүтцүүдэд 2024.03.15-ны 166, 167, 168, 169, 170, 171 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. “Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горим”-ын хэрэгжүүлэх зорилгоор суурь бүтцүүдийн галт тэрэг солилцоонд хяналт тавих ажилтнуудын ажиллах хуваарийг 2024.02.27-ны өдөр баталж зааварчилгаа өгсөн. “ГТХЗНТ” УТҮГ-ын 3 ажилтан 2024.03.01-ний өдрөөс эхлэн хуваарийн дагуу ажиллаж байна.</p>
2	<p>9. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх</p> <p>I-IV улирал: Хоног, 7 хоног, сар, улиралд Яам, төрийн байгууллагыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр шуурхай хангасан байна. Эдгээр мэдээллийг хүргүүлэх механизмыг боловсронгуй болгох арга хэмжээ авсан байна.</p> <p>Хэрэгжилт: Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд 2024.03.22-ны өдрийн байдлаар жилийн 12, хоногийн 410, сарын 24, нийт 446 мэдээг бүрдүүлж хөтөлсөн. Сайдын шуурхай хуралдаанд мидлинг тээвэрлэлтийн мэдээг 5, төмөр замын ачаа тээвэрлэлтийн хоногийн мэдээг ЗТХЯ-ны удирдлагын цахим группт 74 удаа байршуулж танилцуулсан.</p>
3	<p>10. Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний статистикийн хороог төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллээр хангах</p> <p>I улирал: ЗТХЯ, Үндэсний статистикийн хороонд 41 мэдээг тайлагнасан байна.</p> <p>Хэрэгжилт: ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газар, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газарт 2024.01.19-ний өдрийн 32, 2024.02.16-ны өдрийн 103, 104, 2024.03.18-ны 173, 174 дугаартай албан бичгээр төмөр замын тээврийн 24 статистик мэдээг тайлагнаж мэдээллээр хангаж ажилласан.</p>
4	<p>12. Төмөр замын тээвэрт цахим гэрчилгээ /RFID/-г нэвтрүүлж, хяналтыг хэрэгжүүлэх</p>

	<p>I улирал: RFID хяналтын технологийн ашиглалтын судалгаа хийж, систем нэвтрүүлэхэд баримтлах суурь баримт бичиг, ажлын даалгавар боловсруулж ЗТХЯ-нд танилцуулсан байна.</p> <p>Хэрэгжилт: Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх суурь судалгаа, БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх RFID системийн ерөнхий загвар, судалгаа, БНХАУ-д ашиглагдаж буй RFID систем болон авто тээврийн салбарт ашиглагдаж буй "Цахим гэрчилгээ RFID шошго, уншигч суурилуулах" системийн ТЭЗҮ, суурилалтын зураг төсөл, архитектурын бүтэц зэрэг ашиглалтын судалгаа хийж, ЗТХЯ-нд 2024.02.14-ний өдрийн 95 дугаартай албан бичгээр хөдлөх бүрэлдэхүүнд RFID шошго суурилуулах, шаардлагатай цэгүүдийг RFID уншигч бүхий иж бүрэн нэгжээр тоноглох шийдэл бүхий төлөвлөгөө, шаардагдах төсвийг танилцуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдад 2024.02.16-ны өдөр "Чиглэл хүсэх тухай" 112 дугаартай албан бичгээр БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институтийн RFID шошго /TAG/, БНСУ-ын КОЙКА-гийн RFID шошго /TAG/ суурилуулахад шаардлагатай зардлын харьцуулалт болон КОЙКА-гаас ирүүлсэн албан бичгийг хүргүүлсэн. ISO/IEC 18000-63, ISO/IEC: ISO/IEC/JTC1/SC31/WG4, EPCglobal: "EPCglobal Class1 Generation2 (Gen2)" болон БНХАУ-д ашиглагдаж буй QV/НТК 0002-2018 зэрэг стандартын жагсаалтыг гаргаж, RFID буюу Хөдлөх бүрэлдэхүүнийг таних технологийн техникийн ерөнхий шаардлагын ажлын даалгаврыг боловсруулж байна.</p>
5	<p>16. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих</p> <p>I улирал: Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.</p> <p>Хэрэгжилт: Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг зохион байгуулах тухай 06 дугаартай хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2024.01.04-ний өдөр хүргүүлсэн. "ГТХЗНТ" УТҮГ-аас 1 ажилтан тендерийн үнэлгээний хороонд ажиллаж БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилгыг 2024.01.22-ны өдөр tender.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Тендерийг 2024.02.14-ний өдөр нээсэн. Үнэлгээний хорооны дүгнэлт, тайлан, холбогдох баримт ТХААГ-аас 2024.02.23-ны өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" А-1/1067 дугаартай албан бичгээр ирснийг Койкагийн суурин төлөөлөгчийн газарт 2024.02.26-ны 137 дугаартай албан бичгээр хүргүүлж 2024.03.15-ны дотор гэрээ байгуулахыг мэдэгдсэн. Койкагийн суурин төлөөлөгчийн газрын 2024.03.11-ний өдрийн 2024-37 дугаартай албан бичгээр гэрээ байгуулах хугацааг 2024.03.29-ний өдрийг хүртэл сунгах хүсэлт гаргасныг ТХААГ-т 2024.03.12-ны өдрийн 155 дугаартай албан бичгээр хүргүүлж тус газрын 2024.03.14-ний өдрийн А-2/1262 дугаартай албан бичгээр ирүүлсэн хариуг 2024.03.15-ны 164 дугаартай албан бичгээр Койкад уламжилсан.</p>
6	<p>19. Хөдлөх бүрэлдэхүүний улсын нэгдсэн тооллого зохион байгуулах, бүртгэл хийх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх</p> <p>I улирал: Тайлант жилд Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжит хөдлөх бүрэлдэхүүний тоог тодорхойлсон байна. Төвийн дүрэмд нэмэлт оруулах тухай сайдын тушаал батлагдсан байна.</p> <p>Хэрэгжилт: Тайлант жилд худалдан авах, түрээслэх хөдлөх бүрэлдэхүүний төрөл, тоог хөдлөх бүрэлдэхүүний эрэлт хэрэгцээ, суурь бүтцүүдийн багтаамж, галт тэрэгний урсгалын тооцоололд үндэслэн 2024 онд Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжит хөдлөх бүрэлдэхүүний тоо, судалгааг 2024.02.02-ны өдрийн 67 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т танилцуулсан. Төмөр замын тээврийн салбарт хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч хуулийн этгээд болон хөдлөх бүрэлдэхүүний тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, тооллого зохион байгуулах эрхзүйн орчныг бүрдүүлэхээр төвийн дүрэмд нэмэлт оруулах санал, сайдын тушаалын төслийг 2024.03.25-ны өдрийн 234 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлээд байна. 2024.03.26-27-ны өдөр бүх төрлийн ачааны вагоныг, 2024.04.23-24-ний өдөр зүтгүүр, зорчигчийн вагон, төмөр замаар явдаг бусад техникийн нэгдсэн тооллого, бүртгэлийг зохион байгуулахаар хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч 53 хуулийн этгээдэд 2024.03.20-ны өдөр 175, 177-228 дугаартай албан бичгийг хүргүүлж урьдчилсан тооллого (2024.03.22-ны өдрийн байдлаар)-оор 9 байгууллагын 967 хөдлөх бүрэлдэхүүнийг тоолоод байна.</p>

7	<p>27. Шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, сул орон тоог нөхөх, цалин хөлс, нэмэгдэл хөлс, урамшуулал, тусламж, ээлжийн амралт олгох зэрэг хүний нөөцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх</p> <p>I улирал: Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна. ХАБЭА-н төлөвлөгөө батлагдсан байна. Хүний нөөцийн сул 6 орон тоог нөхөж албан тушаалын тодорхойлолтын шаардлагад нийцсэн, шалгуур хангасан иргэнийг томилсон байна.</p> <p>Хэрэгжилт: "ГТХЗНТ" УТҮГ-ын захирлын 2024.01.05-ны өдрийн А/01, 2024.01.10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. 2024.03.25-ны өдрийн байдлаар 2 албан тушаалыг тухайн албан тушаалын чиг үүрэгт хамгийн ойр хамааралтай ажилтнаар хавсран гүйцэтгүүлж байна.</p>
---	--

3.2.Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврын хэрэгжилт:

Сайдын албан даалгавар	Заалтын тоо	Хэрэгжилтийн түвшин /хувиар/				Биелэлт /хувь/
		100	70	30	0	
2023 оны 01 дүгээр албан даалгавар	4	-	4	-	-	70.0
2023 оны 02 дугаар албан даалгавар	1	-	1	-	-	70.0
2024 оны 01 дүгээр албан даалгавар	7	-	5	2	-	58.6
	12	-	10	2	-	63.3

"Хэрэгжилт хангалтгүй" 30%-ийн хэрэгжилттэй 2 заалт:

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Хэрэгжүүлэх заалт	Хэрэгжилт
1	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны "Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай 01 дүгээр албан даалгавар	<p>2.8.Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон шинэ техник технологи нэвтрүүлэх, стандарт норм, дүрэм журмыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлыг эрчимжүүлэх;</p> <p>2.10.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллах орчин нөхцөл, шинэ техник, технологи, инновацын шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;</p>	<p>Монгол Улсын бүх хөдлөх бүрэлдэхүүнд RFID шошго суурилуулах, шаардлагатай цэгүүдийг RFID уншигч бүхий иж бүрэн нэгжээр тоноглох төлөвлөгөө боловсруулж, шаардагдах төсвийг тодорхойлж Зам, тээврийн хөгжлийн яаманд 2024.02.14-ний 95 дугаартай албан бичгээр танилцуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдад 2024.02.16-ны өдөр "Чиглэл хүсэх тухай" 112 дугаартай албан бичгээр БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институтын RFID шошго /tag/, БНСУ-ын КОЙКА-гийн RFID шошго /tag/ суурилуулахад шаарлагатай зардлын харьцуулалт болон КОЙКА-гаас ирүүлсэн албан бичгийг хүргүүлээд байна.</p> <p>"ГТХЗНТ" УТҮГ-ын 2024 оны төсөвт ажлын байрны түрээсийн зардалд 66 сая төгрөг батлагдсан. Ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, батлагдсан төсөвт багтааж түрээсийн төлбөр зарцуулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.1.2-т заасны дагуу</p>

		харьцуулалтын аргаар тендер зохион байгуулахаар ТХААГ-т 2024.02.16-ны өдрийн "Чиглэл хүсэх тухай" 105 дугаартай албан бичгийг хүргүүлж 2024.03.05-ны өдрийн А-2/1148 дугаартай албан бичгээр хариу хүлээн аваад байна.
--	--	--

3.3.Захирлын тушаалын хэрэгжилт:

Тушаалын тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн түвшин /хувиар/				Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлт /хувь/
		100	70	30	0			
15	21	10	3	2	1	2	2	79.4

“Хэрэгжээгүй” 0%-ийн хэрэгжилттэй 1 заалт:

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	д/д	Хэрэгжүүлэх заалт
1	Хариуцлагатай жижүүр томилох тухай 2024.02.02 Дугаар А/05	4.	3.Хариуцлагатай жижүүр томилж ажиллуулсан тухай тайланг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст үүрэг болгосугай.

“Хэрэгжилт хангалтгүй” 30%-ийн хэрэгжилттэй 2 заалт:

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Хэрэгжүүлэх заалт
1	2024.01.10 Дугаар А/02 Үнэлгээний хороо байгуулах тухай	2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагаанд оролцогчдыг ил тод, өрсөлдөх тэгш боломжоор ханган, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллахыг үнэлгээний хорооны гишүүдэд үүрэг болгосугай.
2	Төлөвлөгөө батлах тухай 2024.01.10 Дугаар А/03	2.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст даалгасугай. (Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө)

3.4.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	Үүнээс							Биелэлт (хувиар)
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
Захиргаа, санхүүгийн хэлтэс	43	11	2	9	3	1	2	15	75.0

Биелэлт хангалтгүй үнэлэгдсэн 6 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

“Үр дүнгүй” буюу 0%-ийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:

1	21. Захирлын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах, тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтлөх, нэгж ажилтанд шуурхай хүргэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах
---	---

	Тухай бүр: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгавар, гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад цаг үеийн асуудлыг хэлэлцэж, явцын мэдээллийг сонсож, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажилласан байна.
2	22. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах I улирал: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 арга хэмжээ зохион байгуулсан байна. Хэрэгжилт: ЗТХЯ, Авлигатай тэмцэх газраас хамтран 2024.01.09-ний өдөр зохион байгуулсан ХАСХОМ (Хөрөнгө орлогын мэдүүлэг) гаргах цахим сургалтад "ГТХЗНТ" УТҮГ-ын 4 албан хаагч хамрагдсан.

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

1	41. Төвийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй эрхзүйн 5 баримт бичгийг нэгтгэж боловсруулах, 2 баримт бичгийг хүчингүй болгох I улирал: <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн чиглэлийн 2 хөтөлбөр, 1 журмыг нэгтгэж шинэчлэн баталсан байна. • Шагнал олгох журам, Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг нэгтгэж шинэчлэн баталсан байна. • Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн ажиллах заавар, Захирлын зөвлөлийн ажиллах журмыг хүчингүйд тооцсон байна. Хэрэгжилт: Төвийн захирлын 2024.02.16-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг, мөн өдрийн А/09 дүгээр тушаалаар “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах заавар”-ыг хүчингүй болсонд тооцсон.
---	--

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50%-ийн үнэлгээтэй 3 арга хэмжээ:

1	6. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулж батлуулах, архивт баримт хүлээн авах I улирал: <ul style="list-style-type: none"> • БНШК хуралдаж, ХХНЖ болон архивт баримт хүлээн авах хуваарийг баталсан байна. • ХХНЖ-ын дагуу бүрдэл бүрэн баримтыг бүрэн хүлээн авсан байна. Хэрэгжилт: Төвийн 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төвийн архивт баримт бичиг хүлээж авах ажил хийгдэж байна. 2024.03.14-ний өдрийн байдлаар архивт өгөх нийт баримтын 52.8 хувь буюу 4391 хуудас 30 боть (хадгаламжийн нэгж)-ийг цаасаар, 895 хуудас, 171.1 МВ багтаамжтай, 79 баримтыг цахимаар хүлээж авсан.
2	7. 2023 онд хөтлөгдсөн баримт бичгийг зохих журмын дагуу төвийн архивт шилжүүлэх I улирал: Товьёо, баталгааны хуудас үйлдэж хадгаламжийн нэгж болгон цаасан болон цахим хэлбэрээр архивт шилжүүлсэн байна. Хэрэгжилт: Үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр баталсан захирлын тушаал, өргөдөл гомдол, явуулсан болон ирсэн бичиг, бүртгэлийн дэвтэрийг архивласан. 29.1 МВ 711 хуудас 77 баримтыг цахимаар, 105 баримт бүхий 1084 хуудас, 9 хадгаламжийн нэгж (боть)-ийг цаасаар хүлээлгэн өгсөн. 2024.03.27-ны өдрийн байдлаар ЗСХ-ээс архивт шилжүүлэх 22 нэр, төрлийн баримтын 13 буюу 59.1 хувийг хүлээлгэн өгсөн.
3	38. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгыг барих I улирал: Барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Хэрэгжилт: Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороонд төвийн нягтлан бодогч ажиллаж Үнэлгээний хороо тендерийг 2024.02.14-ний өдөр нээсэн. Үнэлгээний хорооны дүгнэлт, тайлан, холбогдох баримт ТХААГ-аас 2024.02.23-ны “Зөвлөмж хүргүүлэх тухай” А-1/1067 дугаартай албан бичгээр ирснийг Койкагийн суурин төлөөлөгчийн газарт 2024.02.26-ны 137 дугаартай албан бичгээр хүргүүлж 2024.03.15-ны дотор гэрээ байгуулахыг мэдэгдээд байна. Койкагийн суурин төлөөлөгчийн газрын 2024.03.11-ний өдрийн 2024-37 дугаартай албан бичгээр гэрээ байгуулах хугацааг 2024.03.29-ний өдрийг хүртэл сунгах хүсэлт гаргасныг ТХААГ-т 2024.03.12-ны өдрийн 155 дугаартай албан бичгээр хүргүүлж тус газрын 2024.03.14-

ний өдрийн А-2/1262 дугаартай албан бичгээр ирүүлсэн хариуг 2024.03.15-ны 164 дугаартай албан бичгээр Койкад уламжилсан.

3.5.Нэгжийн сарын төлөвлөгөөний хэрэгжилт:

Сар	Нийт	Хэрэгжилтийн түвшин /хувиар/							Биелэлт
		100	90	70	50	30	0	ХБ	
Захиргаа, санхүүгийн хэлтэс									
1 сар	9	8	1	-	-	-	-	-	98.9
2 сар	16	12	-	2	-	1	1	-	85.6
Дүн	25	20	1	2	-	1	1	-	90.4
Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс									
1 сар	16	15	-	-	-	1	-	-	95.6
2 сар	26	24	-	-	1	-	-	-	94.2
Дүн	42	39	-	-	1	1	-	-	94.8
Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс									
1 сар	6	6	-	-	-	-	-	-	100
2 сар	6	6	-	-	-	-	-	-	100
Дүн	12	12	-	-	-	-	-	-	100
Нийт	79	71	1	2	1	2	1	-	94.2

3.6.Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

д/д	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Хэрэгжилтийн дундаж хувь
			100	70	30	0			
1	8.2. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	8	1	7	-	-	-	76.4	
2	8.3 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	-	6	-	-	-	79.0	
3	8.4 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	10	6	-	1	-	3	90.0	
4	8.5 Үзүүлж байгаа үйлчилгээ	1	-	1	-	-	-	75.0	
5	8.6 Бусад мэдээлэл	3	-	2	1	-	-	63.0	
Дүн		28	7	16	2	-	3	79.2	

3.7.Шилэн дансны хөтлөлт:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээлэл	Мэдээлэл хугацаандаа оруулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)			Мэдээлэл оруулах хугацаа болоогүй	Дундаж хувь
				100	70	30		
1	Төсөв, гүйцэтгэл	14	12	-	-	-	2	100
2	Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт	9	8	-	-	-	1	100
3	Бусад	13	12	-	-	-	1	100
Дүн		36	32	-	-	-	4	100

3.8.Туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилт:

Төлөвлөгөөний нэр	Нийт арга хэмжээ	Үүнээс							ХБ	Биелэлт (хувиар)
		100%	90%	70%	50%	30%	0%			
“Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	14	3	1	2	2	2	-	4	69.0	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	15	4	-	2	-	-	2	7	66.4	
Мод тарих ажлын төлөвлөгөө	2	-	-	-	-	-	-	2	ХБ	
Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	22	4	-	-	-	1	10	7	28.7	
Дүн	53	11	1	4	2	3	12	20	50.0	

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн:

	Баримт бичиг	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн түвшин /хувиар/						Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлт /хувиар/
			100	90	70	50	30	0			
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	33	8	3	8	7	3	1	3	-	69.0
2	Сайдын албан даалгавар	12	-	-	10	-	2	-	-	-	63.3
3	Захирлын тушаал	21	10	-	3	-	2	1	2	2	79.4
4	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө	43	11	2	9	3	1	2	15	-	75.0
5	Нэгжийн сарын төлөвлөгөө	79	71	1	2	1	2	1	-	-	94.2
6	Нийтийн мэдээллийн ил тод байдал	28	7	-	16	-	2	-	3	-	79.2
7	Шилэн дансны хөтлөлт	36	32	-	-	-	-	-	4	-	100
8	Туслах чанараар баталсан төлөвлөгөө	53	11	1	4	2	3	12	20	-	50.0
Нийт дүн		305	150	7	52	13	15	17	47	2	80.3

Тав. Дүгнэлт

1. Хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний 33, сайдын албан даалгаврын 12, захирлын тушаалын 21, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 43, нэгжүүдийн сарын төлөвлөгөөний 79, нийтийн мэдээллийн ил тод байдлын 28, шилэн дансны 36, туслах чанараар баталсан төлөвлөгөөний 53, нийт 305 арга хэмжээг хамруулж хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

2. Хяналт-шинжилгээнд хамрагдсан арга хэмжээнээс биелсэн 157, хэрэгжих шатанд 65, хэрэгжилт хангалтгүй 15, хэрэгжээгүй 17, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 47,

хүчингүй болсон 2 арга хэмжээтэй, төвийн үйл ажиллагаа 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 80.3%-ийн биелэлттэй байна.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +9.19%-иар өссөн, өмнөх улиралтай харьцуулахад -7.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

4. Хяналтад авсан нийт арга хэмжээний 51.48% нь биелсэн, 21.32% нь хэрэгжих шатанд, 4.92% нь хэрэгжилт хангалтгүй, 5.58% нь хэрэгжээгүй, 15.41% нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 0.66% нь хүчингүй болсон арга хэмжээ эзэлж байна.

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -1.66%-иар буурсан үзүүлэлттэй байна.

6. Сайдын албан даалгаврын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

7. Захирлын тушаалын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +25.16%-иар өссөн үзүүлэлттэй байна.

8. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +8.21%-иар өссөн үзүүлэлттэй байна.

9. Нэгжүүдийн сарын ажлын биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +4.17%-иар өссөн үзүүлэлттэй байна.

10. Хариутай албан бичиг, өргөдөл хүсэлтийн 88.3 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна. Үүнд, тушаалаар 10.64%-ийг, албан бичгээр 44.68%-ийг, цахимаар 17.03%-ийг, утсаар 2.13%-ийг, оролцож, зохион байгуулж 9.58%-ийг, хугацаа хоцроож 4.26%-ийг шийдвэрлэж, шийдвэрлэх шатанд 4.26%, шийдвэрлэх хугацаа болоогүй 2.09%, хариу өгөөгүй бичиг 7.45%-ийг эзэлж байна.

11. Албан бичгийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +20%-иар өссөн үзүүлэлттэй байна.

12. Тайлант улиралд явуулсан бичгийн 59.08%-ийг хариу ирүүлэх бичиг эзэлж байна. 140 хариутай бичгээс 70.9%-д нь хариу ирүүлсэн байна. Хариу ирээгүй 29.1% буюу 39, хугацаа болоогүй 6, нийт 45 бичгийн үлдэгдэлтэй байна.

Зургаа. Санал зөвлөмж

1. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зуны зурмагийн төслүүдийг хүлээн авч 2024 оны галт тэрэгний хөдөлгөөний зуны нэгдсэн зурмагийг журамд заасан хугацаанд баталж мөрдүүлэх;

2. Суурь бүтэц хооронд солилцох, дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөний протоколын хэрэгжилтийн тайлан, шийдвэрлүүлэх саналыг ЗТХЯ-нд танилцуулах, ээлжит зөвлөгөөний удирдамжийг батлуулах;

3. Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 6.5, Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горимын 2.1.2-т заасны дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах болон галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой суурь бүтцүүдэд өгсөн албан даалгаврын биелэлтийг тухай бүр тооцож ажиллах;

4. Нэгдсэн технологийн горимыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжилтийг хангах;
5. Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хүрээнд бүтэц, зохион байгуулалт, санхүү хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, хүний нөөц, эрхзүйн баримт бичгүүдийн төслийг төлөвлөн боловсруулах ажилд яамны төмөр замын асуудал хариуцсан нэгжтэй зөвлөлдөж яам болон төвийн нэгжүүд ямар үүрэг рольтой оролцох талаар ажил үүргийн хуваарилалт хийж хариуцуулах, эзэн биежүүлэх;
6. Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын нэмэлт өөрчлөлт, Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөтлөх, боловсруулах заавар, Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх заавар, Өртөөний технологийн горим боловсруулах зааврын төслийг боловсруулах;
7. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын хэрэгжилтийг хангуулах, салбарын статистик мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох талаар тодорхой ажил зохион байгуулах;
8. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 11, 12, 15 дахь арга хэмжээг үр дүнд хүргэх зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
9. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд аялах ачааны галт тэрэгт STLIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмж суурилуулж турших арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах;
10. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга угсралтын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж барилгын ажлыг эхлүүлэх;
11. Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн тооллого, бүртгэлийн дүн мэдээг нэгтгэх;
12. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартын төсөлд яам болон төмөр замын байгууллагуудаас санал авах;
13. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт баримт бичгийг бүрэн хүлээн авч, архивын баримтад тоо бүртгэл хөтөлж, тооллого зохион байгуулах;
14. ХАБЭА болон албан хэрэг хөтлөлтийн харилцааг зохицуулсан журам, заавруудыг нэгтгэж батлуулах;
15. Захирлын тушаалын хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн 8, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн 10, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн 7 санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

ТАНИЛЦСАН:

“ГТХЭНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

ТНУАСХ-ИЙН ДАУТОГ

А.БУЯННЭМЭХ

Ц.ОЮУНБАТ

Ж.АЛИМАА

БОЛОВСРУУЛСАН:

ЗСХ-ИЙН ХШҮМ

Э.Осоржамбаа
№/28

Э.ОСОРЖАМАА